МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр Дугаар А/204 Алтай хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, тус аймгийн "108 сая мод" тарьж, ургуулах арга хэмжээний хүрээнд Ээж хайрхан уулын отоглох цэгийг түшиглэн говийн уугуул ургамал болох заг болон говийн мод сөөг тарималжуулах ажилын хүрээнд 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгөөр модны тарьц суулгац худалдан авах ажлыг шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т шилжүүлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, гүйцэтгэгчийн ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (С.Амгалан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-ЗА-4 doc

0201900775

Аймгийн Засаг даргын 20 ... оны ... дугаар
сарын ....... –ны өдрийн ........... дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ДСА0042

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦЭХ СУМЫН НЭР, ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

| Д/д | Сумдын нэр | Нийт газар нутгийн хэмжээ /га/ | Бэлчээрийн хэмжээ /га/ | Хөнөөлт мэрэгчид тархсан талбайн хэмжээ /га/ | Тэмцэх шаардлагатай талбайн хэмжээ /га/ | 2023 онд тэмцэх талбайн хэмжээ мян /га/ | Шаардлагатай бактержуулсан будаа мян /тн/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бигэр | 382632 | 351098.1 | 70 | 36 | 1.0 | 1.5 |
| 2 | Шарга | - | 556585 | 488737.5 | 70 | 26 | 1.5 |

__oOo__